



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

“Миг даатгал” ХХК-д дүрмийн сан
(хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн
хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн хэмжээг хувьцаа эзэмшигчдээс нийт 776 000 000.0 /Долоон зуун далан зургаан сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-д эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Д.Зоригт	350 000 000.0	271 600 000.0	621 600 000.0	35.0%
2	Ж.Бат-Орших	140 000 000.0	108 640 000.0	248 640 000.0	14.0%
3	У.Бямбасүрэн	110 000 000.0	85 360 000.0	195 360 000.0	11.0%
4	Х.Ганбаатар	110 000 000.0	85 360 000.0	195 360 000.0	11.0%
5	Хадгаламж банк	100 000 000.0	77 600 000.0	177 600 000.0	10.0%
6	Н.Энхболд	80 000 000.0	62 080 000.0	142 080 000.0	8.0%
7	Г.Батбаяр	50 000 000.0	38 800 000.0	88 800 000.0	5.0%
8	Г.Лхамсүрэн	40 000 000.0	31 040 000.0	71 040 000.0	4.0%
9	Л.Цэцэг-Эрдэнэ	20 000 000.0	15 520 000.0	35 520 000.0	2.0%
	Дүн	1 000 000 000.0	776 000 000.0	1 776 000 000.0	100 хувь

2. Дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Миг даатгал” ХХК /Ж.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

001522